БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 06 өдөр Дугаар А/72 Улаанбаатар хот

Нийслэлийн өвлийн өдөрлөгт оролцох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, Засаг даргын зөвлөлийн хурлын 2014 оны 01 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн өвлийн өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, өдөрлөгт оролцох харьяа хэлтэс албадыг гуравдугаар хавсралтаар, бэлтгэл ажлын төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралтаар, шаардагдах зардал 3,755,000 /гурван сая долоон зуун тавин таван мянга/ төгрөгийг тавдугаар хавсралтаар тус тус баталж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Нягтлан бодогч /Б.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албадууд цасан хотхон байгуулж, уг өдөрлөгт бүрэн зохион байгуулалттайгаар оролцохыг харьяа хэлтэс албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Уг арга хэмжээны үеэр харьяа хэлтэс албадын дунд спортын тэмцээн уралдаан зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо /Б.Дамба/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ОРОСОО

1160200212

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны
02 сарын 06-ны өдрийн 8/72 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Г.ЭНХБОЛД	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Б.ДАМБА	Биеийн тамир, спорт хорооны дарга
Гишүүд:	П.ГАНБАТ	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Ө.БАТЖАРГАЛ	Эрүүл мэндийн нэгдлийн дарга
	А.ГАНБОЛД	Нийтлэг үйлчилгээний албаны дарга
	Л.ГАНБААТАР	Цэргийн штабын дарга
	Б.СҮРЭНХҮҮ	Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга
	Ч.ЭНХБОЛД	Бүртгэлийн хэлтсийн дарга
	Ё.АМАРБАЯСГАЛАН	Онцгой байдлын хэлтсийн дарга
	Б.БАТБОЛД	Замын цагдаагийн тасгийн дарга
	Л.ЖАРГАЛ	Боловсролын хэлтсийн дарга

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны
02 сарын 06 –ны өдрийн А/22 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

1. 09:00 Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үүднээс нэгдсэн байдлаар Хандгайтын "Янзага зуслан" –гийн зүг хөдлөнө. /Цэргийн штаб Л.Ганбаатар/
2. 10:00 Хандгайтын "Янзага" зусланд очиж байрлана. /Биеийн тамир, спортын хороо Б.Дамба/
3. 10:30 "Өвлийн Олимп-2014" болон "Нийслэлийн бүтээн байгуулалт" сэдэвт цасан хотхон байгуулна. / Онцгой байдлын хэлтэс Ё.Амарбаясгалан/
4. 11:00 Өвлийн өдөрлөгийн нээлтийн арга хэмжээнд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцоно. /Нийгмийн хөгжлийн хэлтэс П.Ганбат/
5. 13:00 Байгууллагууд эрүүл хүнсээр аяны хүнс бэлтгэн, үдийн цай зохион байгуулна. / Худалдаа үйлдвэр үйлчилгээний хэлтэс Б.Сүрэнхүү/
6. 14.00-16:00 Өвлийн өдөрлөгийн үеэр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулна. Үүнд:

   Нэг. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас Цасан дээрх бүжгийн тэмцээн зохион байгуулах ба байгууллага тус бүрээс 1 хос тэмцээнд оролцоно.

   Хоёр. Байгууллагууд хамт олныхоо дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулна. / Биеийн тамир, спортын хороо Б.Дамба/

   а/ Биеийн тамир, спортын хороо үйл ажиллагаагаа сурталчилсан ажил зохион байгуулна.

   б/ Нийт хамт олны дунд цасны буухиа, цасны олс таталт, цасны сумо эрэгтэй, эмэгтэй төрөлд зохион байгуулна.

   - Цасны буухиа тэмцээн: Байгууллага бүр 5 гишүүнтэй /эрэгтэй 3, эмэгтэй 2/ баг бүрдүүлж оролцоно.
   - Цасны олс таталт: Байгууллага бүр 8 гишүүнтэй / эрэгтэй 5, эмэгтэй 3/ баг бүрдүүлж оролцоно.
   - Цасны сумо: эрэгтэй, эмэгтэй төрөлд тус бүр нэг тамиирчин оролцуулна.

Анхааруулга: Тэмцээнд оролцох баг тамирчид байгууллагын туг дарцагтай байж, нэг өнгийн хувцасаар жигдэрсэн байна.

7. 16:00 Хаалтын ажиллагаанд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцоно. /Нийгмийн хөгжлийн хэлтэс П.Ганбат/
8. 16:30 Оролцогчид нэгдсэн журмаар хотруу буцна.

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны
02 сарын 06-ны өдрийн А/22 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОХ ХАРЬЯА ХЭЛТЭС АЛБАД

1. Засаг даргын Тамгын газар
2. Бүртгэлийн хэлтэс
3. Татварын хэлтэс
4. Нийгмийн даатгалын хэлтэс
5. Цагдаагийн хэлтэс I, II
6. Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс
7. Биеийн тамир, спортын хороо
8. Эрүүл мэндийн нэгдэл
9. Өмч, газрын харилцааны алба
10. Статистикийн хэлтэс
11. Дүүргийн замын цагдаагийн тасаг
12. Онцгой байдлын хэлтэс
13. Боловсролын хэлтэс
14. Мэргэжлийн хяналтын хэлтэс
15. Хөдөлмөрийн хэлтэс
16. Иргэний бүртгэлийн хэлтэс
17. "Баянгол Шинэ өргөө" ОНӨААТҮГ
18. Хүүхэд гэр бүл хөгжлийн төв
19. Худалдан авах ажиллагааны алба
20. Хороодын ажлын алба

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны
02 сарын 06-ны өдрийн 02 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Цасан хотхон байгуулах	2014.02.06	Е.Амарбаясгалан А.Ганболд Л.Жаргал
2	Автобус , гэр захиалах, өргөмжлөл анонс бэлтгэх, түлээ, хивс, хөгжим аппаратур бэлэн болгох, тайз бэлтгэх, цахилгааны эх үүсвэр шийдэх, гэр тээвэрлэх	2014.02.05	А.Ганболд
3	Эрүүл хүнсээр үдийн хоол цай бэлтгэх Аяны эрүүл хоол хүнс бэлтгэх гал тогоо бэлэн байдалд авч явах	2014.02.07	Б.Сүрэнхүү Л.Ганбаатар
4	Тамгын газрын харьяа хэлтэс, албад, хамт олны дунд спортын гурван төрөлд тэмцээн зохион байгуулах	2014.02.08	Б.Дамба
5	Цасан дээрх бүжгийн тэмцээнд 1 хос бэлтгэн оролцуулах	2014.02.08	П.Ганбат
6	Тэмцээний нэгдсэн дүнг гаргаж Нийслэлийн Биеийн тамир спортын газарт өгөх	2014.02.08	Б.Дамба
7	Цасны баярын техникийн зөвлөгөөнийг зохион байгуулах	2014.02.05 14:00 цагт	П.Ганбат Б.Дамба
8	Харьяа хэлтэс албадыг бүртгэх	2014.02.06 2014.02.08	П.Ганбат Т.Ууганбаяр

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны
02 сарын 06-ны өдрийн А/22 дугаар
захирамжийн тавдугаар хавсралт

ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Автобус унаа	2	120,000	240,000
2	Гэр түрээслэх	5	66,000	396,000
3	Эрүүл хүнсээр үдийн цай бэлтгэх	багцаараа	750,000	750,000
4	Цасан хотхон байгуулах зардал	10*10м2	700,000	700,000
5	Спортын тэмцээн уралдааны шагналын зардал			
	Олс таталтын тэмцээн /эхний 3 байр/	1	200,000	200,000
	Цасны сумо /эрэгтэй, эмэгтэй тус бүр эхний 3 байр/	1	100,000	100,000
	Цасны буухиа /эхний 3 байр/	1	200,000	200,000
6	Өргөмжлөл	9	12,000	108,000
7	Анонс	1,50*1,0 *3ш 2,50*2,0 *1ш	6,000	57,000
8	Бензин А/80	40 л	1,600	64,000
9	Бензин зардал	1	20,000	20,000
10	Түлээ	30 уут	3,000	90,000
11	Өдрийн хоолны зардал	10	23,000	230,000
12	Мөс тээвэрлэх зардал	1	250,000	250,000
13	Гэр тээвэрлэх зардал	1	350,000	350,000
	Нийт дүн			**3,755,000**